**НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 26 өдөр　　　　Дугаар А/108　　　　Улаанбаатар хот

Дархлаажуулалтын 10 хоногийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Дархлаажуулалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/180 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Улаанбурхан өвчнөөс хамтдаа сэргийлье” уриан дор дархлаажуулах ажлыг дүүрэгт 2023 оны 05 дугаар сарын 29-өөс 06 дугаар сарын 05-ны өдрийн хооронд чанар үр дүнтэй зохион байгуулахыг Ажлын хэсэг (Х.Ганбат)-т үүрэг болгосугай.

2.Дархлаажуулалтын 10 хоног зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3.Дархлаажуулалтын 10 хоногийн хүрээнд 8, 10 сартайгаас 8 нас хүртэлх хүүхэд, заавал хийх дархлаажуулалтаас хоцорсон 15 хүртэлх насны хүүхдийг нөхөн дархлаажуулалтад бүрэн хамруулах ажлыг зохион байгуулахыг Боловсролын байгууллагын захирал, эрхлэгч (Э.Соёмбобат, Н.Тунгалаг, С.Отгонтуяа, Ц.Цэцгээ), Хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн хөгжлийн хэлтэс (Б.Цогжавхлан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА　　　　А.СҮХБОЛД

A:\ЛL\2023 он ажил\захирамж
1123000318

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2023 оны ....05.. дүгээр сарын..26... ны өдрийн
А/108... дугаар захирамжийн хавсралт

ДАРХЛААЖУУЛАЛТЫН 10 ХОНОГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч : | Х. Ганбат | Эрүүл мэндийн төвийн дарга |
| Гишүүд: | Н.Нямзав | 1 дүгээр хорооны Засаг дарга |
| | Б.Батзориг | 2 дугаар хорооны Засаг дарга |
| | Э.Соёмбобат | "Хангай" цогцолбор сургуулийн захирал |
| | Н.Тунгалаг | 44 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч |
| | С.Отгонтуяа | 207 дугаар цэцэрлэгийн эрхлэгч |
| | Ц.Цэцгээ | 183 дугаар цэцэрлэгийн эрхлэгч |
| | Д.Дашдэлэг | Хүүхдийн их эмч |
| Нарийн бичгийн дарга: | О. Удвал | Статистикч, вакцинатор ахлах сувилагч |